



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 5/29

Дэлгэрхаан сум

Д.Одончимэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, 2025 оны 08 дүгээр сарын 29-ний бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даваагийн Одончимэгийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн монгол хэл, уран зохиолын багшаар томилон ажиллуулсугай.

2. Д.Одончимэгийн үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, унаа, хоолны нөхөн олговор, холбогдох бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Энхсаруул)-д зөвшөөрсүгэй.

3. Монгол хэл, уран зохиолын багшийн ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Б.Ариунчимэг /Сургалтын менежер/

Гишүүн: Д.Энхчимэг /НУЗАН-ийн ахлагч/

Нарийн бичгийн дарга: Н.Оюундарь /Номын санч, бичиг хэрэг/

4. Д.Одончимэгт мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж ажиллуулахыг сургалтын менежер (Б.Ариунчимэг), эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Б.Тогтохжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Ж.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАХИРАЛ

Ш.ЦЭРЭНДУЛАМ

